



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 161

Улаанбаатар хот

┌ Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх ┐
тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.4, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 39 дүгээр зүйлийн 39.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 3.5.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хавсралтад дурдсан “Соёмбо даатгал” ХХК-ийн нэр бүхий 2 иргэний даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Тогтоол батлагдсантай холбогдуулан даатгалын гэрээ, баталгааны үлдэгдлийн тооцоог хийж, ажлын 10 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэхийг “Соёмбо даатгал” ХХК /Э.Тэмүүжин/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



Санхүүгийн зохицуулах хорооны
2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн
161 дүгээр тогтоолын хавсралт



“Соёмбо даатгал” ХХК-ийн даатгалын төлөөлөгчийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
хүчингүй болгох иргэдийн мэдээлэл

№	Овог	Нэр	Регистрийн дугаар	Тусгай зөвшөөрөл авсан огноо	Шийдвэрийн дугаар /Санхүүгийн зохицуулах хорооны даргын тушаал/	Тусгай зөвшөөрлийн дугаар
1	Санжаа	Хишигт	НФ83012705	2012.01.31	15 дугаар тушаал	2/01/231/209
2	Мөнхтулга	Номин-Эрдэнэ	НЭ92031323	2012.08.23	169 дугаар тушаал	2/01/231/225